



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/546.

Булган сум

┌ Усны тоо бүртгэлийн ажил зохион байгуулах тухай. ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Усны тоо бүртгэлийн ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

3. Усны тоо бүртгэлийн ажилд шаардагдах зардал 9,486,000 (есөн сая дөрвөн зуун наян зургаан мянга) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын “Усны нөөц хамгаалах, ус хангамжийг сайжруулах чиглэл”-ийн арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.


4. Хануй, Сэлэнгэ голын сав газрын захиргаадтай усны тоо бүртгэлийн ажлын гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр)-д, сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хамтарч ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

08. Аймгийн Засаг даргын 20.25 оны  
A/546 дугаар сарын 13.-ны/ний өдрийн  
... дугаар захирамжийн хавсралт



Усны тоо бүртгэлийн ажлын зардлын хуваарилалт

д/д	Сав газрын захиргааны нэр	Нийт зардлын хуваарилалт /төгрөг/
1	2	3
1	Хануй голын сав газрын захиргаа	5,934,000
2	Сэлэнгэ голын сав газрын захиргаа	3,552,000
	<b>Нийт төсөв</b>	<b>9.486.000</b>